



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын ажил дүгнэх заавар, загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.19 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын ажил дүгнэх зааврыг нэгдүгээр, ангийн орлогч, сургалт хариуцсан ахлах байцаагчийн сарын ажил дүгнэх загварыг хоёрдугаар, салааны захирагч /салааны захирагчийн туслах/-ийн томилгоот ээлжийн ажил дүгнэх загварыг гуравдугаар, салааны захирагч /салааны захирагчийн туслах/-ийн сарын ажил дүгнэх загварыг дөрөвдүгээр, тасгийн дарга /аврагч-гал сөнөөгч/-ын томилгоот ээлжийн ажил дүгнэх загварыг тавдугаар, тасгийн дарга /аврагч-гал сөнөөгч/-ын сарын ажил дүгнэх загварыг зургаадугаар, гал унтраах автомашины жолооч /шатны техникч/-ийн томилгоот ээлжийн ажил дүгнэх загварыг долоодугаар, гал унтраах автомашины жолооч /шатны техникч/-ийн сарын ажил дүгнэх загварыг наймдугаар, дуудлага хүлээн авагч /шуурхай удирдлагын оператор/-ийн томилгоот ээлжийн ажил дүгнэх загварыг есдүгээр, дуудлага хүлээн авагч /шуурхай удирдлагын оператор/-ийн сарын ажил дүгнэх загварыг аравдугаар, амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчны сарын ажил дүгнэх загварыг арваннэгдүгээр, техникийн ахлах /механик жолооч/-ын сарын ажил дүгнэх загварыг арванхоёрдугаар, нярвын сарын ажил дүгнэх загварыг арвангуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан заавар, загварыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Ж.Чүлтэмсүрэн)-д даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ  Г.АРИУНБУЯН



0000 834

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн
А/82 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ АНГИЙН АЛБА ХААГЧДЫН
АЖИЛ ДҮГНЭХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврын зорилго нь Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.1 дэх хэсгийг хэрэгжүүлэх, алба хаагчдын бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэхэд чиглэх ба Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэж, үр дүнг тооцоход дагаж мөрдөнө.

1.2. Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан "Гал түймэр унтраах, аврах ангид хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, загвар, заавар батлах тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтад заасан ажил дүгнэх загварыг энэхүү заавраар хэрэгжүүлнэ.

Хоёр. Ажил дүгнэхэд баримтлах зарчим

- 2.1. Шударга, бодитой, сонирхлын зөрчил, субъектив нөлөөллөөс ангид байх;
- 2.2. Үнэлгээ нь алба хаагчийн үндсэн чиг үүрэгтэй холбоотой байх;
- 2.3. Дүгнэх үйл ажиллагаа, үнэлгээ нь ил тод байх;
- 2.4. Алба хаагчийн ажлын үр дүнг дүгнэх, цаашид сайжруулахад чиглэсэн байх.

Гурав. Ажил дүгнэх хугацаа, зохион байгуулалт

3.1. Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын ажлыг дараах албан тушаалтнууд дүгнэнэ.

3.1.1 Ангийн захирагч дараах албан хаагчдын ажлыг дүгнэнэ:

- Салааны захирагчийн томилгоот ээлжинд үүрэг гүйцэтгэсэн ажлыг;
- Салааны захирагчийн болон томилгоот ээлжинд үүрэг гүйцэтгэдэггүй, өдрөөр ажилладаг (ангийн орлогч, сургалт хариуцсан ахлах байцаагч, ахлах жолооч, механик жолооч, нярав, амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчин) алба хаагчдын сарын ажлыг;

3.1.2 Салааны захирагч дараах албан хаагчдын ажлыг дүгнэнэ:

- Томилгоот ээлжинд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын томилгоот ээлжийн ажлыг;
- Салааны алба хаагчдын сарын ажлыг тус тус дүгнэнэ.

3.2. Томилгоот ээлжинд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын ажлыг томилгоот ээлжийн цагийн хуваарийн дагуу тухай бүрт дүгнэнэ.

3.3. Гал түймэр унтраах, аврах ангийн салааны захирагч томилгоот ээлжинд үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдын сарын ажлын дүнг Гал түймэр унтраах, аврах ангийн захирагчид сар бүр танилцуулна.

3.4. Алба хаагчдын жилийн эцсийн үнэлгээг сар бүрийн үнэлгээнд үндэслэн Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч дүгнэнэ.

3.5. Хэрэв алба хаагч хариуцсан салааны захирагчаас өөр салааны захирагчийн томилгоот ээлжинд үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд тухайн ээлжинд үүрэг гүйцэтгэсэн салааны захирагч ээлжийн ажлыг дүгнэнэ.

3.6. Гал түймэр унтраах, аврах ангийн захирагчийг эзгүй үед ангийн орлогч, ангийн захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч дүгнэж болно.

3.7. Алба хаагч томилгоот ээлжинд үүрэг гүйцэтгэх өдөр хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан тохиолдолд тухайн өдрийн үнэлгээг 0 гэж тооцон, сарын ажил дүгнэхэд дундаж үзүүлэлтэд оруулан тооцно.

3.8. Алба хаагч ээлжийн амралттай хугацаанд болон албан ёсны чөлөөтэй үед тухай үеийн томилгоот ээлжийн болон сарын ажлыг дүгнэхгүй.

3.9. Томилгоот ээлжинд үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдын сарын ажлыг дүгнэхдээ тухайн сард томилгоот ээлжинд үүрэг гүйцэтгэсэн өдрүүдийн дундаж оноог 40 оноонд шилжүүлж тооцно. Ингэхдээ дараах аргачлалаар тооцно:

$$Z_{\text{дундаж}} = \frac{Z_{\text{ээлж дундаж}} \times 40}{100}$$

Z_{дундаж} – Сарын ажил дүгнэхэд тооцох томилгоот ээлжинд үүрэг гүйцэтгэсэн онооны дундаж,

Z_{ээлж дундаж} – Томилгоот ээлжинд үүрэг гүйцэтгэсэн дундаж оноо.

3.10. Алба хаагчийн гүйцэтгэсэн ажил тус бүрийг дүгнэхдээ дараах хүснэгтийн дагуу харгалзах оноог өгнө.

№	Ажлын гүйцэтгэл	Өгөх оноо		
		5	10	15
Авбал зохих оноо				
1	Алба хаагч тухайн ажлыг бүрэн гүйцэтгэж, үр дүнтэй зохион байгуулсан	4-5	7-10	11-15
2	Алба хаагч тухайн гүйцэтгэх ажлыг бүрэн гүйцэтгэсэн боловч, үр дүн хангалттай түвшинд хүрээгүй	2-3	4-6	6-10
3	Алба хаагч тухайн гүйцэтгэх ажлыг дутуу гүйцэтгэсэн боловч, тодорхой хэмжээний үр дүн гарсан	1	1-3	1-5
4	Алба хаагч тухайн гүйцэтгэх ажлыг гүйцэтгээгүй, эсвэл тодорхой үр дүн гараагүй	0	0	0

3.11. Мэргэжлийн онолын сургалт бүрийн дараа тухайн сэдвийн хүрээнд 10-аас доошгүй асуулттай мэдлэг бататгах шалгалт авч, уг шалгалтын дүнгээр онолын сургалтын үнэлгээг тооцно.

3.12. Мэргэжлийн дадлага сургалтын оноог цагийн хуваарийн дагуу өдөр тутмын дадлага сургалтад оролцож, авсан үнэлгээгээр тооцно.

3.13. Алба хаагчийн сарын ажлын гүйцэтгэлийг дараах байдлаар дүгнэнэ:

90-100 оноо – “А” буюу “Маш сайн”

80-89 оноо – “В” буюу “Сайн”

70-79 оноо – “С” буюу “Хангалттай”

60-69 оноо – “D” буюу “Дутагдалтай”

0-59 оноо – “F” буюу “Хангалтгүй”

Дөрөв. Бусад

4.1. Ажлын гүйцэтгэл, үр дүнгээрээ хамт олноо тэргүүлэн, “Маш сайн” дүгнүүлсэн нь алба хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу сайшаал хүртээх, шагнах үндэслэл болно.

4.2. Ажлын гүйцэтгэл, үр дүнгээрээ “Хангалтгүй” дүгнүүлсэн нь алба хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ноогдуулах үндэслэл болно.

4.3. Алба хаагч нь ажил дүгнэсэн үнэлгээтэй санал нийлээгүй тохиолдолд, үндэслэл бүхий тайлбарыг дараагийн шатны удирдах албан тушаалтанд бичгээр гаргаж, шийдвэрлүүлнэ.

---оОо---



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2023 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн
 АРД дугаар тушаалын эрвэнгэдүгээр хавсралт
 Гал түймэр унтраах, аврах дугаар ангийн дугаар амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчин, дүгнэх загвар хүснэгт
 ын сарын ажлыг

2023 оны 2 дугаар сарын -ны өдөр Үйлдвэржилтийн үйлчилгээний газар Улаанбаатар хот

№	Сар	Гүйцэтгэх ажил												Дүн		Танилцсан алба хаагчийн гарын үсэг	Дүгнэсэн алба хаагчийн гарын үсэг	
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Авсан нийт оноо /хувь/	Үнэлгээ			
Мерийн дугаар		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12					
Авбал зохих оноо		10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	100			
1	1 дүгээр сар																	
2	2 дугаар сар																	
3	3 дугаар сар																	
4	4 дүгээр сар																	
5	5 дугаар сар																	
6	6 дугаар сар																	
7	7 дугаар сар																	
8	8 дугаар сар																	
9	9 дүгээр сар																	
10	10 дугаар сар																	
11	11 дүгээр сар																	
12	12 дугаар сар																	
Дундаж оноо																		

